



БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

МОГОД СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН 2022 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН,
ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: БУА-2023/121/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn
БУЛГАН ХОТ
2023 он

Дарга, Тэргүүлэх аудитор: Б.Эрдэнэ
Утас:70342580
Цахим хаяг: erdeneb@audit.gov.mn
Аудитын менежер: Ж.Энхцоодол
Утас:70342716
Цахим хаяг: enkhtsoodolj@audit.gov.mn
Ахлах аудитор: П.Содном
Утас:70342495
Цахим хаяг: Sodnomp@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт
 2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл
 3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....
 - 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа
 - 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин
 - 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал
 - 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт
 4. Аудитын тайлан
 - 4.1 Ерөнхий зүйл
 - 4.2 Материаллаг байдал
 - 4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....
 - 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал
 - 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
 - 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал
5. Аудитын илрүүлэлт
 6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**БУЛГАН АЙМГИЙН
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,
Жаргалант баг, Булган сум, Булган аймаг, 63082
Утас/Факс: 7034-2580
E-mail: bulgan@audit.gov.mn

2023.08.24 № 137
танай _____ ны № _____ т

БУЛГАН АЙМГИЙН МОГОД СУМЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН ДАРГА
Г.БУЛГАН ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Могод сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Могод сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна.

Тус байгууллага 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд нийт 5 зорилтын хүрээнд 17 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөж жилийн эцсийн байдлаар 78.1 хувийн биелэлттэйгээр тайлагнасан, батлагдсан төсвийн 89.08 хувийг зарцуулсан байна.

Аудитын гол асуудал

Эрүүл мэндийн даатгалын сангаас өмнөх оны авлага 54355.2, тайлант онд 473572.2, орон нутгийн төсвөөс 36492.0, нэмэлт санхүүжилтээр 2113.1 мянган төгрөгийн санхүүжилт авч, 2022 онд авлага эхний үлдэгдэл 54,355.2 мянган төгрөгийг бүрэн барагдуулж шинээр 22.6 мянган төгрөгийн авлага үүссэн, өглөгийн данс нь эхний болон эцсийн үлдэгдэлгүй байна.

Могод сумын Эрүүл мэндийн төвийн санхүүгийн тайлангийн аудитад нөлөөлөх гол асуудал илрээгүй байна.

006020171

Бусад асуудлын хэсэг

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



Б.ЭРДЭНЭ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>187,840,844.58</u>	<u>202,367,371.71</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	13,343,602.00	47,763,526.67
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	13,343,602.00	47,763,526.67
3121	Төгрөг	13,343,602.00	47,763,526.67
31211	Төрийн сангийн харилцах	6,970,060.97	47,763,526.67
31215	Нэмэлт санхүүжилтийн харилцах	6,373,541.03	-
33	АВЛАГА	54,355,200.00	26,622.50
335	Бусад авлага	54,355,200.00	26,622.50
3351	Байгууллагаас авах авлага	54,355,200.00	26,622.50
35	БАРАА МАТЕРИАЛ	120,142,042.58	154,577,222.54
351	Түүхий эд материал	29,444,125.50	33,386,472.25
35130	Эм боох материал	29,444,125.50	33,386,472.25
354	Хангамжийн материал	90,697,917.08	121,190,750.29
35410	Бичиг хэргийн материал	1,933,180.00	2,877,330.00
35420	Аж ахуйн материал	29,745,280.08	33,833,080.08
35430	Сэлбэг хэрэгсэл	2,636,500.00	1,541,500.00
35440	Түлш, шатах тослох материал	660,000.00	660,000.00
35450	Барилгын засварын материал		
35460	Хүнсний материал	2,468,421.00	3,826,840.00
35470	Бусад хангамжийн материал	53,254,536.00	78,452,000.21
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>604,547,961.66</u>	<u>597,700,603.15</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	604,547,961.66	597,700,603.15
392	Биет хөрөнгө	585,343,961.66	578,496,603.15
39201	Барилга, байгууламж, орон сууц	504,584,955.34	504,584,955.34
39202	Хуримтлагдсан элэгдэл	(55,576,350.42)	(84,550,248.30)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	69,090,667.00	69,090,667.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(24,264,544.35)	(36,176,544.51)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	128,807,532.96	185,520,187.96
39206	Хуримтлагдсан элэгдэл	(46,736,611.29)	(66,752,320.77)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	25,155,969.00	25,155,969.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(15,732,304.45)	(18,376,062.57)
39214	Бусад үндсэн хөрөнгө	12,120,000.00	12,120,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(12,105,352.13)	(12,120,000.00)
393	Биет бус хөрөнгө	19,204,000.00	19,204,000.00
39301	Програм хангамж	300,000.00	300,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(300,000.00)	(300,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	19,204,000.00	19,204,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>792,388,806.24</u>	<u>800,067,974.86</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>792,388,806.24</u>	<u>800,067,974.86</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	792,388,806.24	800,067,974.86
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	156,185,903.37	156,185,903.37
51101	Өмч: - төрийн		
512	Хуримтлагдсан үр дүн	432,473,139.71	440,152,308.33
51210	Өмнөх үеийн үр дүн	432,473,139.71	432,473,139.71
51220	Тайлант үеийн үр дүн	-	7,679,168.62
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	203,729,763.16	203,729,763.16
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>792,388,806.24</u>	<u>800,067,974.86</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	950,977,023.44	512,177,282.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	221,449,901.48	-
120	Нийтлэг татварын бус орлого	221,449,901.48	-
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	221,449,901.48	-
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих		-
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	221,449,901.48	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	729,527,121.96	512,177,282.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	386,549,342.00	-
131004	Төсөв болон дамжуулан зээлдүүлсэн зээлээс эргэж төлөгдөх	3,655,002.00	-
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	382,894,340.00	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	209,583,410.00	2,113,122.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж		1,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	209,583,410.00	1,113,122.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	62,302,311.96	36,492,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	62,302,311.96	36,492,000.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	71,092,058.00	473,572,160.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	71,092,058.00	473,572,160.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	791,606,389.66	591,246,747.52
21	УРСГАЛ ЗАРДАЛ	791,606,389.66	591,246,747.52
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	760,306,389.66	590,264,433.27
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	353,087,513.00	318,924,550.24
210101	Үндсэн цалин	220,680,544.87	186,470,223.05
210102	Нэмэгдэл	89,420,987.23	94,020,118.94
210103	Унаа хоолны хөнгөлөлт	3,916,885.26	3,484,000.00
210104	Урамшуулал	39,069,095.64	34,950,208.25
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	45,320,470.18	39,290,230.09
210201	Тэтгэврийн даатгал	33,303,156.73	29,118,168.40
210202	Тэтгэмжийн даатгал	2,888,660.10	2,652,053.78
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,475,101.23	2,111,562.96
210204	Ажилгүйдлийн даатгал	583,749.00	491,676.81
210205	Эрүүл мэндийн даатгал	6,069,803.12	4,916,768.14
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	31,771,911.96	34,798,085.75
210301	Гэрэл, цахилгаан	2,170,179.00	3,655,634.00
210302	Түлш, халаалт	29,496,232.96	30,892,451.75
210303	Цэвэр, бохир ус	105,500.00	250,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	21,287,090.00	29,108,450.70
210401	Бичиг хэрэг	2,388,000.00	2,215,630.00
210402	Тээвэр, шатахуун	13,973,300.00	19,197,490.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,815,590.00	1,628,177.50
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,984,500.00	1,566,200.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	125,700.00	4,500,953.20
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал		-
2105	Нормативт зардал	245,043,305.77	90,157,032.98
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	236,282,058.77	81,655,671.98
210502	Хоол, хүнс	8,201,247.00	8,501,361.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	560,000.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,100,300.00	7,583,500.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	59,100.00	-
210604	Урсгал засвар	1,041,200.00	7,583,500.00

2107	Томилолт, зочны зардал	648,000.00	1,486,000.00
210702	Дотоод албан томилолт	648,000.00	1,486,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,508,722.00	1,578,070.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	946,722.00	1,016,150.00
210803	Даатгалын үйлчилгээ	70,000.00	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	61,500.00	61,200.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	40,000.00	16,500.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,350,000.00	443,420.00
210807	Газрын төлбөр	40,500.00	40,800.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	59,539,076.75	67,338,513.51
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,659,050.00	3,778,500.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	53,880,026.75	63,560,013.51
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	31,300,000.00	982,314.25
2132	Бусад урсгал шилжүүлэг	31,300,000.00	-
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	22,000,000.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	9,300,000.00	-
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	982,314.25
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	982,314.25
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	159,370,633.78	(79,069,465.52)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	159,370,633.78	(79,069,465.52)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	675,171,921.96	566,532,482.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	675,171,921.96	566,532,482.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	386,549,342.00	-
131004	Төсөв болон дамжуулан зээлдүүлсэн зээлээс эргэж төлөгдөх	3,655,002.00	-
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	382,894,340.00	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	209,583,410.00	2,113,122.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж		1,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	209,583,410.00	1,113,122.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	62,302,311.96	36,492,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	62,302,311.96	36,492,000.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	16,736,858.00	527,927,360.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	16,736,858.00	527,927,360.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	615,208,019.96	495,615,557.33
21	УРСГАЛ ЗАРДАЛ	615,208,019.96	495,615,557.33
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	583,908,019.96	494,633,243.08
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	353,086,613.00	318,924,550.24
210101	Үндсэн цалин	220,679,644.87	186,470,223.05
210102	Нэмэгдэл	89,420,987.23	94,020,118.94
210103	Унаа хоолны хөнгөлөлт	3,916,885.26	3,484,000.00
210104	Урамшуулал	39,069,095.64	34,950,208.25
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	45,320,470.18	39,290,230.09
210201	Тэтгэврийн даатгал	33,337,203.73	29,118,168.40
210202	Тэтгэмжийн даатгал	3,089,125.78	2,652,053.78

210203	ҮОМШӨ-ний даатгал	2,475,101.23	2,111,562.96
210204	Ажилгүйдлийн даатгал	583,749.00	491,676.81
210205	Эрүүл мэндийн даатгал	5,835,290.44	4,916,768.14
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	32,431,911.96	34,798,085.75
210301	Гэрэл, цахилгаан	2,170,179.00	2,384,030.00
210302	Түлш, халаалт	30,156,232.96	32,164,055.75
210303	Цэвэр, бохир ус	105,500.00	250,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	32,391,840.00	25,666,470.00
210401	Бичиг хэрэг	1,251,900.00	2,015,150.00
210402	Тээвэр, шатахуун	13,973,300.00	19,197,490.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,815,590.00	1,839,530.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,783,400.00	1,513,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	12,567,650.00	1,100,800.00
2105	Нормативт зардал	107,146,112.82	59,647,037.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	97,554,988.82	48,537,257.00
210502	Хоол, хүнс	6,588,124.00	9,859,780.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,003,000.00	1,250,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,556,500.00	6,650,100.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	730,000.00	-
210604	Урсгал засвар	1,826,500.00	6,650,100.00
2107	Томиллот, зочны зардал	648,000.00	1,486,000.00
210702	Дотоод албан томиллот	648,000.00	1,486,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,568,722.00	1,754,070.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,006,722.00	1,082,150.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	110,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	70,000.00	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	61,500.00	61,200.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	40,000.00	16,500.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,350,000.00	443,420.00
210807	Газрын төлбөр	40,500.00	40,800.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	7,757,850.00	6,416,700.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	7,757,850.00	6,416,700.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	31,300,000.00	982,314.25
2132	Бусад урсгал шилжүүлэг	31,300,000.00	-
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	22,000,000.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	9,300,000.00	-
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	982,314.25
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	982,314.25
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	59,963,902.00	70,916,924.67
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	46,620,300.00	36,497,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	46,620,300.00	36,497,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	46,620,300.00	36,497,000.00
222001	Тоног төхөөрөмж	46,620,300.00	36,497,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(46,620,300.00)	(36,497,000.00)
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	=	=
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	13,343,602.00	34,419,924.67
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		13,343,602.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	13,343,602.00	47,763,526.67

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	156,185,903.37	203,729,763.16	273,102,505.93	633,018,172.46
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	156,185,903.37	203,729,763.16	273,102,505.93	633,018,172.46
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	159,370,633.78	159,370,633.78
C08	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	156,185,903.37	203,729,763.16	432,473,139.71	792,388,806.24
D01	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	156,185,903.37	203,729,763.16	432,473,139.71	792,388,806.24
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	156,185,903.37	203,729,763.16	432,473,139.71	792,388,806.24
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	7,679,168.62	7,679,168.62
D09	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	156,185,903.37	203,729,763.16	440,152,308.33	800,067,974.86

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	596,238,600.00	531130243.08
21	УРСГАЛ ЗАРДАЛ	596,238,600.00	531130243.08
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	596,238,600.00	531130243.08
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	337,991,000.00	318924550.24
210101	Үндсэн цалин	199,034,800.00	186470223.05
210102	Нэмэгдэл	107,063,200.00	94020118.94
210103	Унаа хоолны хөнгөлөлт	4,347,000.00	3484000.00
210104	Урамшуулал	27,546,000.00	34950208.25
210105	Гэрээт ажлын хөлс		
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	48,248,800.00	39290230.09
210201	Тэтгэврийн даатгал	34,729,200.00	29118168.40
210202	Тэтгэмжийн даатгал	3,379,900.00	2652053.78
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,703,900.00	2111562.96
210204	Ажилгүйдлийн даатгал	676,000.00	491676.81
210205	Эрүүл мэндийн даатгал	6,759,800.00	4916768.14
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	34,814,100.00	34798085.75
210301	Гэрэл, цахилгаан	2,400,000.00	2584030.00
210302	Түлш, халаалт	32,164,100.00	31964055.75
210303	Цэвэр, бохир ус	250,000.00	250000.00
210304	Байрны түрээс		
2104	Хангамж, бараа материалын зардал	31,587,500.00	25666470.00
210401	Бичиг хэрэг	3,669,200.00	2015150.00
210402	Тээвэр, шатахуун	20,852,900.00	19197490.00

210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,496,000.00	1,839,530.00
210404	Ном, хэвлэл		
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,569,400.00	1,513,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,000,000.00	1,100,800.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал		
2105	Нормативт зардал	60,988,600.00	59,647,037.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	49,172,000.00	48,537,257.00
210502	Хоол, хүнс	10,498,900.00	9,859,780.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,317,700.00	1,250,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	64,052,900.00	39,642,100.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	30,000,000.00	30,000,000.00
210602	Тавилга	20,000,000.00	
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл		
210604	Урсгал засвар	14,052,900.00	9,642,100.00
2107	Томилолт, зочны зардал	1,842,100.00	1,486,000.00
210701	Гадаад албан томилолт		
210702	Дотоод албан томилолт	1,842,100.00	1,486,000.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах		
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,451,800.00	1,754,070.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,582,200.00	1,082,150.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	288,000.00	110,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	69,600.00	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	61,200.00	61,200.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	39,600.00	16,500.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,350,000.00	443,420.00
210807	Газрын төлбөр	40,800.00	40,800.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	20,400.00	-
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх		
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	13,261,800.00	9,921,700.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	13,261,800.00	9,921,700.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	596,238,600.00	565,550,167.75
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	36,492,000.00	35,509,685.75
132001	Орон нутгийн төсвөөс	36,492,000.00	35,509,685.75
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих		
1340	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	559,746,600.00	527,927,360.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих		
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	559,746,600.00	527,927,360.00
134003	Нийгмийн даатгалын сангаас эмнэлгүүдэд олгох санхүүжилт	-	-
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	-	2,113,122.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих		2,113,122.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		13,343,602.00
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		47,763,526.67

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Могод сумын эрүүл мэндийн төв нь хүн амд эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ болон нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх байгууллага юм.

Могод сумын ЭМТ нь 2022 онд “Эмнэлгийн ажилтны ёс зүйн хэм хэмжээг сахисан, ээлтэй орчинд эрүүл мэндийн тусламж үйлчилгээг жигд хүртээмжтэй, чанартай үзүүлж, эрүүл боловсролыг тасралтгүй олгосноор эрүүл урт наслалтыг дэмжихэд оршино” гэсэн зорилго тавьж зорилгын хүрээнд 3 зорилтыг хэрэгжүүлж ажиллахаар төлөвлөжээ. Үүнд:

1. Эрүүл аж төрөх эрүүл мэндээ хамгаалах зөв зан үйлийг төлөвшүүлж өвчлөл нас баралтыг бууруулна.
2. ЭМ-ийн үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг чанаржуулан өвчлөлөөс урьдчилан сэрийлнэ.
3. Үйлчлэгчид үзүүлэх тусламж үйлчилгээг хөнгөн шуурхай чанартай болгож үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжийг дээшлүүлнэ гэсэн зорилтуудыг тавьжээ.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар : Эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үзүүлэх тусгай зөвшөөрөл бүхий төрийн байгууллага юм.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Эрүүл мэндийн даатгалын сангаас нэг иргэнээр тооцон санхүүжилт авдаг, санхүүжилтийн 20% нь гүйцэтгэлээр буюу гүйцэтгэлийн санхүүжилтийн систем нэвтэрч цахим шилжилт хийгдэж бодит цагийн горим баримтлан ажиллах болсон.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзлээ.

Дотоод аудит аудиторын орон тоо, чиг үүрэг байхгүй ба төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа санхүүгийн хяналт дотоод аудитын алба хэрэгжүүлж байна. Тайлант онд тус албанаас Булган аймгийн Засаг даргын баталсан удирдамжийн дагуу төлөвлөгөөт шалгалт хийж 69.0 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт, зөрчил арилгах 1 албан шаардлага өгсөн байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Могод сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Могод сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 7679.1 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		Өөрчлөлт
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	13,343.6	47,763.5	34,419.9
Авлага	54,355.2	26.6	-54,328.6
Бараа материал	120,142.0	154,577.2	34,435.2
Үндсэн хөрөнгө	604,548	597,700.6	-6,847.4
Нийт хөрөнгө	792,388.8	800,067.9	7679.1
Өр төлбөр	0	0	0
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	792,388.8	800,067.9	7679.1
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	792,388.8	800,067.9	7679.1

Бараа материалын дансны үлдэгдэл 154,577.2 мянган төгрөг болж 34,435.5 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд төсвийн хөрөнгөөр 93,179.9 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, аймгийн Эрүүл мэндийн газраас 66,532.9 мянган төгрөгийн хөрөнгө үнэ төлбөргүй шилжиж ирж орлогоор бүртгэжээ. Тайлант онд үйл ажиллагаандаа 125,277.7 мянган төгрөгийн бараа материал зарцуулж, үнэ төлбөргүй шилжүүлсэн болон акталж устгасан бараа материал байхгүй байна.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 815,975.8 мянган төгрөг болж өмнөх оноос 56,712.7 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 36,497.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж худалдан авч, Эрүүл мэндийн яамнаас 17,600 мянган төгрөгийн шинжилгээний 2 аппарат, аймгийн Эрүүл мэндийн газраас 2615.7 мянган төгрөгийн тоног төхөөрөмж үнэ төлбөргүй шилжин ирж орлогоор бүртгэсэн байна. Үнэ төлбөргүй шилжүүлсэн болон акталж устгасан үндсэн хөрөнгө байхгүй байна.

Авлага дансны эхний үлдэгдэл Эрүүл мэндийн даатгалын сангаас авах 54,355.2 мянган төгрөгийн авлага бүр барагдаж, тайлант онд шуудан холбооны 26.6 мянган төгрөгийн авлага шинээр үүссэн байна.

Өр төлбөрийн данс нь эхний болон эцсийн үлдэгдэлгүй байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 449,544.1, орон нутгийн төсвөөс 41,803.3, Эрүүл мэндийн даатгалын сангаас 28,600.0 мянган төгрөгийн санхүүжилт авч нийт зарлагыг 576,851.9 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр Эрүүл мэндийн даатгалын сангаас 559,746.6, орон нутгийн төсвөөс 36,492.0 мянган төгрөгийг орлогоос бүрдүүлэхээр байна.

Гүйцэтгэлээр Эрүүл мэндийн даатгалын сангаас 527,927.3, орон нутгийн төсвөөс 36492.0 мянган төгрөгийн санхүүжилт олгож, тогтмол зардлын үлдэгдэл 982.3 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 531130.2 мянган төгрөг буюу 89.1 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлаас цалин, НДШ-ийг 28025.0, хангамж, бараа материалын зардлыг 5921.0, эд хогшил, урсгал засварын зардлыг 24410.8 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/					
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	80302 нэг иргэнд ногдох нормативаар	258,170.7	249,884.0	8,286.7	96.7%
2	81603 үндсэн мэргэжлийн тусламж үйлчилгээ	218,456.9	210,381.1	8,075.8	96,3%
3	83603 Дээд шатны төсвөөс хуваарилсан	83,119.0	83,119.0	0	100

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансны оны эхний үлдэгдэл 6373.5 мянган төгрөгийн үндсэн үйл ажиллагааны дансанд шилжүүлэн зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Могод сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Булган аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор П.Содном гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Ж.Энхцоодол, тэргүүлэх аудитор Б.Эрдэнэ нар тус тус хэрэгжүүлсэн.

Могод сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Булган аймаг дахь Төрийн аудитын газрын 2023 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 01 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр тайлант оны батлагдсан төсөв сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг бага гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны батлагдсан төсвийн 531,130.2 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 7,966.9 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж цалин, НДШ-ийг 28025.0, хангамж, бараа материалын зардлыг 5921.0, эд хогшил, урсгал засварын зардлыг 24410.8 мянган төгрөгөөр тус тус хэмнэгдсэн ч зарим зүйл заалтыг зөрчсөн байна. Үүнд

Хүнсний материалын дансны үлдэгдлийг тооллогын бүртгэлтэй тулган баталгаажуулахад 435.2 кг махны үлдэгдэлтэй, оны эцэст худалдан авч нөөцөлсөн байна. Өдрийн хэрэглээгээр бодоход 6-7 сар хэрэглэх мах бэлдсэн нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д "Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно:", 15.1.6-д "нөөцлөх шаардлагатай бараа, материалыг үр ашиггүй удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөх;" гэсэн заалттай нийцэхгүй байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 148 мэдээллээс хугацаандаа оруулсан 142 мэдээлэл, хугацаа хоцорсон 6, таван сая төгрөгөөс дээш 28.0 сая төгрөгийн гүйлгээ мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Тайлант онд завсрын аудит хийгдээгүй.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 3927.0 мянган төгрөгийн 2 зөвлөмж өгч биелэлтийг байгууллагын даргын 2022 оны 06 дугаар сарын 24-ний өдрийн 37 тоот албан бичгээр хариу ирүүлж, зөвлөмж бүрэн хэрэгжсэн байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	2	768.0	2	768.0	100
Албан шаардлага	1	926.3	1	926.3	100
Зөвлөмж	3	700.0	3	700.0	100
Нийт дүн	6	2394.3	6	2394.3	100

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарал татахуйц асуудал байхгүй гэж үзлээ.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 53352.6 мянган төгрөгийн алдаа¹ илэрснээс аудитын явцад 11907.7 мянган төгрөгийн алдааг залруулж, 41444.9 мянган төгрөгийн алдааг дахин давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өглөө.

Үүнд: Шуудан холбооны зардлаас 26622.5 төгрөгийн илүү шилжүүлж авлага үүссэн боловч санхүүгийн тайланд авлагад бүртгээгүй, үр дүнгийн тайланд цалин, нийгмийн даатгалын 11881030 төгрөгийг хооронд гүйлгэн тайлагнасан нь НББ-ийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-д "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ:" 14.4.2-д "бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага;" гэсэн заалтыг зөрчсөн байна.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

Аудитаар нийт 7023.5 мянган төгрөгийн зөрчил² илэрснээс, 7023.5 мянган төгрөгийн 2 албан шаардлага хүргүүлжээ.

5.1 Төлбөрийн акт

Байхгүй

5.2 Албан шаардлага

1. Бараа үйлчилгээний бусад зардлаас шуудан холбооны 304,600, урсгал засварт 1,868,800, хөрөнгө бэлтгэхэд 1023300 төгрөгийг тус тус зориулалт бус зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;" 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;" гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн.

2. Хүнсний материалын дансны үлдэгдлийг тооллогын бүртгэлтэй тулган баталгаажуулахад 435.2 кг махны үлдэгдэлтэй, оны эцэст худалдан авч нөөцөлсөн байна. Өдрийн хэрэглээгээр бодоход 6-7 сар хэрэглэх мах бэлдсэн нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д "Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно:", 15.1.6-д "нөөцлөх шаардлагатай бараа, материалыг үр ашиггүй удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөх;" гэсэн заалтыг зөрчсөн байна.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Байгууллагын эзэмшилд бүртгэлтэй 43 нэр төрлийн 41,444,944 төгрөгийн элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн хөрөнгүүдийг дахин үнэлээгүй тайланд тусгасан байна.

Энэ нь Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолыг хэрэгжүүлж ажиллагаагүй байна. Энэ нь "ТБ", "ҮЗБ", "ИББ" гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Төрийн өмчийн бодлого зохицуулалтын хорооны 271 тоот тогтоолоор баталсан 7.1-д заасан "Төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийг ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Өгсөн зөвлөмж: Элэгдлийн нийт хэмжээ ашиглалтын хугацаагаараа балансын үнээ бүрэн нөхсөн хөрөнгийн ашиглалтын хугацаа, үнийг шинэчлэн тогтоох болон данс бүртгэлээс хасах арга хэмжээ авч ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил

Байгууллагын эзэмшилд бүртгэлтэй 43 нэр төрлийн 41,444,944 төгрөгийн элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн хөрөнгүүдийг дахин үнэлээгүй тайланд тусгасан	1	41444.9					1	41444.9
Дүн								
Нийт дүн	1	41444.9					1	41444.9